Нийслэлийн Засаг даргын 2001 оны 37 дугаар захирамжаар хүчингүй

# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 12 дугаар сарын 16 өдөр | Дугаар А-251 | Улаанбаатар хот

Орон сууц, нийтийн аж ахуйн компаний дүрмийг шинэчлэн батлах тухай

1.Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйн компаний (УҮГ) дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны (хуучин нэрээр) 1991 оны 344 дүгээр тогтоолын 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Ж.НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг даргын 1997 оны А/25 тоот захирамжийн хавсралт

УХБ-11

# УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН КОМПАНИ "УУГ"-ИЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйн компани "УУГ" /энэ дүрэмд цаашид "компани" гэнэ/ нь хотын хэмжээнд Орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх, салбарын хэмжээнд өмч хувьчлалын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, орон сууцны фондын хөтийн төлөвийг тодорхойлох, ашиглалтын хяналт, засвар үйлчилгээний материаллаг баазыг бэхжүүлэхтэй холбогдсон асуудлаар нэгдсэн бодлого, төрийн өмнөөс явуулах, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг төрийн өмчид тулгуурлан ажиллах Улсын үйлдвэрийн газар бөгөөд харьяа аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг зохицуулж удирдана.

## Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Компани нь аж ахуйн бүрэн төсөөн дээр бие даан ажиллах Орон сууц, нийтийн аж ахуйн конторууд, Барилга засвар үйлчилгээний контор, Автобааз, "Монгол лифт" компани зэрэг улсын үйлдвэрийн болон төслөөр, менежментийн хувьд хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдтэй ажиллана.

2.2. Компани нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гаргасан захирамж, тушаал болон эрх зүйн бусад акт, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

2.3. Компани нь бие даасан баланс, данстай, тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж тушаал гаргана. Компанийн үйл ажиллагааг захирал удирдаж, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Захирагчийн ажлын албаны өмнө ажил хариуцаж тайлагнана.

2.4. Компанийн захирлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн захирамжаар томилж, гэрээний үндсэн дээр ажиллуулна.

7-9 2.5. Хамтын удирдлагаар асуудал шийдэх зорилгоор компани нь хүний бүрэлдэхүүнтэй захирлын зөвлөлтэй байна.

## Гурав. Компанийг байгуулах, бүртгэх

3.1. Компанийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар

хотын захирагчийн шийдвэрээр байгуулна.

3.2.Компани улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авч үйл ажиллагаа явуулна.

3.3.Компани, түүний харьяа аж ахуйн нэгжүүд нь улсын татварын албанд бүртгүүлсэн байна.

## Дөрөв.Компаний эд хөрөнгө

4.1.Компаний эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэх бөгөөд дүрмийн сангийн нийт хэмжээ 61.2 тэрбум төгрөг байна.

4.2.Дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх тохиолдолд "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4.3. Уг эд хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомж болон дүрмэндээ нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмшин ашиглаж, захиран зарцуулна.

## Тав.Компаний үүрэг

5.1.Компани нь харьяа аж ахуйн нэгжийг байгуулах, татан буулгах, өөрчлөх асуудлыг бие даан шийдвэрлэнэ.

5.2.Аж ахуйн нэгжийн дарга нарыг компаний захирлын тушаалаар томилж, харилцан хамтран ажиллах гэрээ байгуулна.

5.3.Компани нь Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн салбарын техник зохион байгуулалтын болон эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.4.Компани нь Улаанбаатар хотын орон сууцны барилга байгууламж, шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд шинжлэх ухаан техникийн ололтыг нэвтрүүлэх бодлого боловсруулан түүнийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

5.5.Хотын орон сууцыг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангуулах, үйлчилгээний цэг салбар нэр төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

5.6.Орон сууц, үйлчилгээний болон дулааны нэгдсэн төв зэрэг барилга байгууламжийг ашиглалтанд хүлээж авахад оролцож техникийн дүгнэлт гарган холбогдох акт, баримт бичигт гарын үсэг зурна.

5.7.Орон сууц, нийтийн аж ахуйн барилга байгууламжинд техникийн үзлэг, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх болон их, урсгал засвар, тохижилтын ажлыг тогтоосон журмын дагуу явуулахад аж ахуйн нэгжүүдэд байнгын хяналт тавина.

5.8.Орон сууцны засвар, үйлдвэрлэлийн баазыг өргөтгөн бэхжүүлэх чиг бодлогыг хэрэгжүүлж, засварын цехийн хүчин чадлыг бүрэн ашиглаж, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авахын зэрэгцээ материал хангамжийн нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.

5.9.Харьяа аж ахуйн нэгжүүдийн тайлан тэнцэтгэл, статистикийн болон үйлчилгээний мэдээг сар, улирал, жилээр авч нэгтгэн холбогдох байгууллагуудад үнэн зөв тогтмол мэдээлж байх, санхүү аж ахуйн үйл ажиллагаанд шинжилгээ судалгаа, хяналт шалгалт хийж, шаардлагатай арга хэмжээ авна.

5.10.Компани нь үйлдвэрлэл үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх, үйлчилгээнд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, орон сууц нэгдсэн журмаар барих, худалдан авах, тэргүүний ажилтан ажилчдыг шагнаж урамшуулах, удирдлагын зардлыг санхүүжүүлэх, гачигдал тохиолдсон хүмүүст тэтгэмж олгох зэрэг зорилгоор аж ахуйн нэгжүүдийн ашгаас байгуулсан өөрт үлдэх хөрөнгөөс 50 хүртэл хувиар төвлөрүүлж зарцуулна.

5.11.Аж ахуйн нэгжүүдийн мэдэлд байгаа барилга, үндсэн хөрөнгийг тайлан тэнцэтгэлээс, тайлан тэнцэтгэлд шилжүүлэх, түүнчлэн их засварын хөрөнгийн эх үүсвэр хүрэлцэхгүй нөхцөлд аж ахуйн нэгжүүдийн хооронд зохицуулалт хийх, актлах, балансаас хасах асуудлыг дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

5.12.Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд мөрдөх үнэ, тариф, техникийн нөхцөлийг боловсруулж хянан батлах, шаардлагатай бол холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх, мөрдөлтөнд хяналт тавина.

5.13.Шинжлэх ухаан техникийн дэвшил, шинэ техник технологийг орон сууц, нийтийн аж ахуйн хэмжээнд нэвтрүүлэх, энэ чиглэлээр заавар, зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулна.

5.14.Аж ахуйн нэгжүүдийг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, удирдах ажилтныг шилж сонгох, тэдний мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, шинээр мэргэжилтэн бэлтгэх зэргээр боловсон хүчний бодлогыг системийн хэмжээнд нэгтгэн явуулна.

5.15.Орон сууц хувьчлалтай холбоотой хууль тогтоомж, бусад эрх зүйн актыг сурталчлах, Орон сууц, нийтийн аж ахуйн конторууд, иргэдэд зааварчилга, зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулна.

5.16.Улаанбаатар хотод хувьчлагдсан болон төрийн мэдэлд байгаа сууцны бүртгэл, мэдээллийн санг хотын хэмжээгээр нэгтгэн бүрдүүлж хөтлөнө.

5.17.Хүн амьдрах шаардлага хангасан болон үл хангасан орон сууцны жагсаалтыг гаргуулан магадлан шинжлэх хороогоор дүгнэлт хийлгэн батлуулах.

5.18.Дээд байгууллага нь хувьчлахаар шийдвэрлэсэн төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон сууцыг хувьчлах асуудлыг нутаг дэвсгэрийн дагуу хүлээн авч шийдвэрлүүлнэ.

5.19.Орон сууц өмчлөгчдийн холбоо байгуулахад арга зүйн туслалцаа үзүүлнэ.

## Зургаа.Компанийн эрх

6.1.Харьяа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж тэднээс шаардлагатай материал, мэдээ судалгааг гаргуулан авна.

6.2.Аж ахуйн нэгжүүд нь хууль тогтоомжинд нийцээгүй буюу хөдөлмөрчид нийгмийн эрх ашигт харшилсан тушаал, шийдвэр гаргавал түүнийг цуцлана.

6.3.Харьяа аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтны илтгэл сонсголыг авч хэлэлцэнэ. Тэдгээрээс зөрчил, дутагдал гаргавал зохих хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

6.4.Гадаад орны болон холбогдох байгууллагуудтай тогтоосон журмын дагуу харилцаа, холбоо тогтоон хамтран ажиллана.

6.5.Харьяа аж ахуйн нэгж, хүмүүсийн дунд төрөл бүрийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулан байр эзлүүлж, шагнаж урамшуулна.

## Долоо.Компанийг өөрчлөн байгуулах,татан буулгах

7.1.Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Нийслэлийн Засаг дарга болоод Улаанбаатар хотын Захирагчийн захирамжаар шийдвэрлэнэ.

___о0о___